

## ФИЛОСОФИЙН ТҮҮХ СУДЛАЛД

Г.ЭРДЭНЭБАЯР  
МУИС, НШУС, Философийн тэнхим

**Түлхүүр үг:** Философи, Философийн түүх, Онол, Арга зүй

**Товч утга:** Хүн төрөлхтний оюуны соёлын охь шим болсон философийн мэдлэг үүссэн цагаас эдүгээ хүртэл хөгжлийн урт хугацаа туулсан билээ. Энэ явцдаа философийн өөрийн хөгжил өмнөх шатнаасаа дээж аван хөгжингүй тэлөв байдалд шилжих хэлбэрээр хөгжиж иржээ.

Энэхүү үйл явцыг тэмдэглэн хойч үедээ өвлүүлэн үлдээж үнэлэлт, дүгнэлт өгдөг салбар бол философийн сапшгүй бүрэлдэхүүн болох философийн түүхийн шинжлэх ухаан болой.

Философийн түүхийн шинжлэх ухаан хаана, хэдийд үүссэн, ямар хэлбэрээр хэрхэн хөгжиж ирсэн хийгээд гол болгож буй арга зүй нь ямар байв зэрэг асуудлыг энэхүү өгүүллийн хүрээнд товч авч үзэх оролдлого хийв.

Философийн түүх бол хүн төрөлхтний философи сэтгэлгээний хөгжил, үндсэн үе шат хөгжлийн зүй тогтлын тухай, философийн мэдлэгийн мөн чанарын тухай шинжлэх ухаан юм. Философийн түүх бол философийн шинжлэх ухаан өөрөө өөрийгөө ухамсарлаж, зүй тогтлоо танин мэдэж буй хэлбэр юм. Судлан үзвээс хөгжлийн харьцангуй өндөр шатан дээр философийн түүхийн эх үүсвэр гарч ирдэг. Энэ шат нь МЭӨ 5-4 дүгээр zuуны үе буюу эртний Грек оронд боол эзэмшлийн харилцаа хөгжлийн дээд шатандаа дэвшин орж, философид Платоны болон Демокритын шугам нэгэnt ялгарч байсан тэр үе болой. Философиийн түүхийн мэдлэгийн эх үүсвэр (эдүгээ мэдэгдэж байгаагаар) анх эртний Грекийн нэрт философич Платоны зохиол бүтээлүүдэд тавигдсан гэж үздэг. Платоны зохиол бүтээлүүд түүний өмнөх үеийнхний үзэл санааг судлах чухал сурвалж болдог билээ. Тухайлбал, "Софист", "Кратил" зэрэг зохиолдоо тодорхой асуудлаархи өмнөх үеийн сэтгэгчдийн үзэл санааг, ялангуяа Сократын ба Софистуудын үзэл санааг гарган тавьж байсан юм. Платон зохиол бүтээлдээ бусад нэрт сэтгэгчид ялангуяа Сократын нэрийн дор зөвхөн өөрийнхөө үзэл санааг гаргасан зүйл их байдгийг басхүү харгалзан үзэх шаардлагатай болдог\*.

Тиймээс Платоны зохиолуудад ихээкэн шүүмжлэлтэй хандах хэрэгтэй. Их Аристотелийн зохиол бүтээлүүдэд философийн түүхийн мэдлэг

\* Р.Дарьхүү, Г.Эрдэнэбаяр "Философийн түүх" тэргүүн дэвтэр УБ., 2004 он. 126-127 дахь тал

## МУИС Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

ухаан нэлээд хөгжингүй хэлбэрээр гарч ирсэн. "Метафизик" зохиолдоо Аристотель өмнө үеийн сэтгэлгээг шүүмжлэлтэйгээр задлан шинжилж дүгнэсэн байдаг.

Энэ асуудлыг задлан шинжилж шүүмжлэх гэсэн чухал элемент шинээр бий болж байна. Аристотелоос хойшхи элинизмийн үе философийн түүхийн мэдлэг, ухааны хөгжилд шинэ шат болсон хэмээн үздэг. Энэ үед Христосын шашин бий болж аажмаар нийгмийн сэтгэлгээнд зонхилох болсон. Энэ үеэс эхлэн өмнөх үеийн сэтгэлгээний бүхий л уламжлалыг шашны эрх ашиг, нөлөөнд тохируулан тайлбарлах хандлага гарч ирсэн байна.

Философи сэтгэлгээ зөвхөн Христосын шашны үзэл санааны бэлтгэп, үр хөврөл байсан мэтээр дүрслэх, өмнөх үеийн сэтгэлгээний уламжлалаас зөвхөн энэ зорилгод нийцэх хэсгүүдийг түүн авах болсон. Гэвч энэ үед философийн түүхийн мэдлэг ор орхигдож үгүй болсон биш, харин ч философийн түүхийн бие даасан шинжтэй зохиолууд гарч байсан. Тухайлбал, эртний Грекийн нэрт сэтгэгч, түүхч Диоген Лаэртскийг дурдаж болно\*\*. Тэр үеийн бүтээлүүдийн нэг онцлог бол өмнөх үеийн сэтгэгчдийн тухай аливаа мэдээ баримтыг ямарваа зааг ялгаа, шүүмжгүйгээр бүгдийг нь эмхтгэж хүүрнэн өгүүлсэн хэлбэртэй байдаг юм. Энэ нь эмпирик түвшиндээ тохирч байгаа хэрэг юм.

Дундад зууны үед нийгмийн амьдралын бүх салбарт Христосын шашин хуваарьгүй ноёрхож байлаа. Шинжлэх ухаан, түүний дотор философийн шинжлэх ухаан мөн чанараараа шашинтай зөрчилдөж, түүнийг үгүйсгэхэд хүрч байснаар хаягдан орхигдоход хүрч байв.

Платон, Аристотелийн зохиолууд дахь зэрим үзэл санааг уламжлан авах түүнийг Христос шашны удиртгал хэмээн харуулах оролдого хийгдэж байв. Гэхдээ энэ үед философийн түүхийн мэдлэг огт орхигдсон хэрэг биш юм. Европын орнууд, мөн Араб, Дорно дахины орнуудад Эртний Грек, Ромын философи сэтгэлгээний ашигтай үр хөврөлийг уламжилж авах, нэгтгэн дүгнэх ажил ихээхэн хийгдсэн. Ялангуяа энд Араб, Дорно дахины нэрт сэтгэгч Аш-Шахрастаны бүтээлийг онцлон дурьдах хэрэгтэй. Тэрээр "Шашны бүлэг ба философиин сургуулиуд" гэдэг том хэмжээний бүтээл туурвисан. Түүний гол шинэлэг зүйл нь нийт дэлхий дахины философиин түүхийг бичих гэсэн явдал юм. Нөгөө талаар сийлсөн философи сэтгэлгээний бүх

\*\* Нэрт философчдын амьдрал үйл ажиллагааны тухай" (МЭ-III зуун)

түүх бол эсрэг тэсрэг үзлүүдийн зөрчил тэмцлийн түүх гэдгийг гарган харуулсан явдал юм. Энэ тухайн цаг үедээ дэвшилтэт үзэл санаа байв.

Дундад зууны философиийн түүхийн мэдлэгийн өөр нэг бүрэлдэхүүн хэсэг бол Энэтхэг, Төвд, Монгол зэрэг Буддын шашинт орнуудад гарч ирсэн үзэл баримтлалууд юм. Эдгээр улс орнуудад голчлон Энэтхэг, Төвд, Хятад зэрэг оронд дэлгэрсэн шашин философиийн урсгалууд ялангуяа, Буддын шашин философиийн түүхийг ихэд анхаарч нягтлан судалж иржээ. (Төвдийн Лувсанням, Монголын Агваанбалдан зэрэг). Эдгээр сэтгэгчдийн бүтээлүүд ихэвчлэн "Тогтсон тааллын ёс" гэдэг нэрээр улаанжилж иржээ.

Тэд юуны өмнө философиийн түүхийн судалгааны түүхэн зарчмын үзэл санааг товойлгон тавьсан тал харагддаг. Доод доод тогтсон тааллуудын учир дутагдалтай талыг дээд дээд тогтсон тааллын ёс нь шүүмжлэн няцаах замаар нийт хүн төрөлхтний сэтгэлгээ философиийн соёл төгөлдөржин хөгжиж иржээ. Тиймээс доод тогтсон таалалд хүрэх шат болно хэмээн үзсэн нь буй. "Мэргэд гаражын орон" сурвалж бичигт 100 гаруй шашин философиийн урсгал, чиглэлийг тодорхойлсон байдаг.

Философиийн түүхийн мэдлэг ухаан төлөвшин хөгжиж байсан явдал бол тэдгээр оронд философи сэтгэлгээ нь өөрөө өндөр шатанд хүрч хөгжиж байсны нэгэн нотолгоо юм.

Шинэ үеийн философиийг үндэслэгч Ф.Бекон дундад зууны үзэл суртал түүнээс схоластик философиийг хүн төрөлхтнөөс өртөнцийг танин мэдэхүйд учирсан саадын нэг гэж шүүмжилж байв. Ф.Бекон, Р.Декарт, Б.Спиноза нар үзэхдээ өмнөх үед хэдийчинээ олон философичид байхын хирээр төдийчинээ өлон философи байдаа. Өмнөх үеийн бүх философиийн түүх бол зөвхөн алдаа ташаарал, эндүүрлийн түүх мөн. Шинэ үеийн философи бол түүнээс хамаарахгүй шинэ зүйл гэж үзэж байв. Энэ үед философиийн түүхийн мэдлэг ор орхигдож үгүй болоогүй.

Харин ч шинэ үед философиийн түүхийн бие даасан анхны бүтээлүүд гарч ирсэн билээ\*.

\* Деланд "Философиийн шүүмжлэлт түүх" III бот

И.Фосс "Философи ба философиийн сургуулийн тухай"

Т.Стенли "Философиийн түүх"

Г.Хорн "Философиийн түүхийн 7 ном"

Я.Бруккер "Эртнээс эдүгээг хүртэлх философиийн шүүмжлэлт түүх"

И.Эберхард "Философиийн түгээмэл түүх"

## МУИС Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

Ер нь шинэ үеийн гол хандлага бол философиин мэдлэг ухааныг шашны номполын нөлөөнөөс ангижуулах, философиин үзэл сургаалыг тухайн үеийн түүх, нийгмийн байгуулал, шинжлэх ухааны хөгжилтэй нь холбож үзэх явдал байв. Философиин түүхийг анх удаа шинжлэх ухаан болгон авч үзэх оролдлогыг Германы философич Г.В.Ф.Гегель хийсэн юм.

Гегель анх удаа Берлинний их сургуульд философиин түүхийг тусгайлсан судлагдахуун болгон тавьсан. Түүний лекцүүд хожим нь олон удаа хэвлэгджээ. Тэрээр философи гэдэг бол сэтгэлгээнд илэрхийлэгдсэн эрин үе гэж үзэж байв. Философиин аливаа үзэл сургаал бол тухайн эрин үеэ төвлөрүүлэн илэрхийлж байдаг. Тийм учраас философи нь тухайн ард түмний нийгмийн амьдралтай салшгүй холбогдотой байдаг. Философи, философиин түүх хоёрын хооронд ямарваа гэлэшгүй зааг гэж байхгүй. Гегель философиин түүхийг цэвэр сэтгэлгээний түүх, дан ганц танин мэдэхүйн үйл явц болгож үзсэн байдаг. Үзэл санааны зөрчил бол философиин түүхийн хөдөлгөгч хүч гэж үзээд философиин үзэл сургаалыг нийгэм түүхийн бүх үзэгдэл үйл явцтай нь холбож үзэх оролдлого хийжээ. Эндээс Гегель нийгэм, философиин сэтгэлгээний хөгжлийн эх сурвалж нь эрин цагийн оюун ухаан мөн хэмээн дүгнэсэн байдаг. Үүнээс гадна тэрээр шинэхэн үеийн философи бол өмнөх бүх зөрчлийн үр дүн мөн. Тийм учраас философиин нэг ч тогтолцоо няцаагддаггүй. Тухайн философиин зарчим нь няцаагддаг биш харин тухайн зарчмыг туйлын төгс тодорхойлолт гэсэн зарчим нь няцаагдаж байгаа юм хэмээн дүгнэсэн нь эдүгээ ч онол, практикийн чухал ач холбогдолтой дүгнэлт болжээ.

Өмнөх үеийн аливаа философиийг судлах эцсийн зорилго нь манай өнөө үеийн философиийг хөгжүүлэх явдал байх ёстой. Өмнөх үеийн сэтгэгчдийн сэтгэлгээнээс суралцаж түүгээр өнөөгийн философи сэтгэлгээг баяжуулах явдал чухал ач холбогдолтой.

Өрнө дахины философиин түүх судлалд Марксизм томоохон системд тооцогддог. Маркс, Энгельс, Ленин нар философиийг материализмын байр сууринаас авч үзэх тал дээр ихээхэн зүйл хийсэн нь буй.

Марксист философиин түүх судлалд онол, арга зүйн олон чухал асуудал хөндөгдсөн байдгийг ор тас үгүйсгэж бслохгүй. Түүнчлэн марксизмд шүүмжлэлтэй хандаж болохоор зүйл буйг ч мартаж болохгүй. Жишээлбэл, Марксист философиин түүх судлалын нэг үндсэн тулгуур зарчим болох философиин түүхийн судалгааны ангич, намч байх зарчмыг дурьдаж болно. Энэ зарчмыг баримтална гэдэг нь судлагдаж буй үзэл санааны материалист буюу идеалист мөн чанарыг нь илрүүлэн гаргаж, түүний судалгааны бүх

үеийн турш баримтална гэсэн үг юм. Түүнчлэн философиин түүхийн судалгаанд намч зарчмыг баримтална гэдэг бол судлагдаж буй үзэл онолын дэвшүүлэн гаргасан баримтлал нэг бүрийг марксист философи, диалектик материализмын байр сууринаас үнэлэн дүгнэх шаардлага юм. Философиин түүх судалгаанд ангич зарчмыг хэрэглэнэ гэдэг нь тухайн үзэл онолыг төрүүлж гаргасан түүний дэвшилтэт болон сөрөг талыг нь ялгаж, дүгнэпт өгөхдөө марксизмын байр суурийг тууштай баримтална гэсэн утгатай байжээ.

Энэ болон бусад зарчмууд дээр үндэслэж, удирдлага болгох үндсэн дээр Марксизм нь нийт хүн төрөлхтний философи сэтгэлгээний түүхийг авч үзсэн байдаг. Дэлхий дахини философиин түүхийг марксизмын өмнөх үе, марксизмын дараах үе гэсэн хоёр томоохон үед куваан үзэх явдал ч бий.

Аливаа шинжлэх ухаан, түүний дотор философи сэтгэлгээний үечлэлийн асуудал бол арга зүйн хувьд нэлээд бэрхшээлтэй асуудлын нэг юм. Нөгөө талаар, нийгэм болон эдийн засгийн хөгжлийн түүхэн томоохон үеүд нь сэтгэлгээний үечлэлийг тодорхойлох үндэс болдог байна.

Үргэлжлэл бий.